



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 11 сарын 22 өдөр

Дугаар А/774

Ховд

Сахилгын шийтгэл ногдуулах тухай


Шилэн дансны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1.1, Хөдөлмөрийн тухай хуулийн 131 дүгээр зүйлийн 131.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Шилэн дансны мэдээллийг 2019 оны 3 дугаар улирлын байдлаар оруулаагүй, тайлан илгээгээгүй хавсралтад дурьдсан албан тушаалтнуудад сануулах сахилгын шийтгэл ногдуулсугай.
2. Хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй байгууллагын нягтлангуудад сахилгын шийтгэл ногдуулж ажиллахыг байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.
3. Шилэн дансны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авахыг байгууллагын дарга нарт даалгасугай.
4. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж, Шилэн дансны хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  Б.ДҮГЭРЖАВ



Аймгийн Засаг даргын 2019 оны
11 дүгээр сарын 22-ны өдрийн
А/774 дүгээр захирамжийн хавсралт



САХИЛГЫН ШИЙТГЭЛ НОГДУУЛСАН АЛБАН
ТУШААЛТНЫ НЭРС

д/д	Байгууллагын нэр	Албан тушаал	Нэр
1	Орон нутгийн өмчийн газар	Дарга	Ш.Нохойжав
2	Номын сан	Эрхлэгч	Т.Эрдэнэтуяа
3	Музей	Захирал	Д.Мягмарцоож
4	Сум дундын ой анги	Дарга	Ц.Даваахүү
5	Ховд суварга ОНӨААТҮГ	Дарга	Л.Хатанбаатар
6	Жаргалант сумын 6 дугаар цэцэрлэг	Эрхлэгч	Ш.Чанцалхүү
7	Жаргалант сумын 7 дугаар цэцэрлэг	Эрхлэгч	Б.Төгсжаргал
8	Цэцэг сумын сургууль	Захирал	Д.Мөнхтөр
9	Цэцэг сумын цэцэрлэг	Эрхлэгч	Б.Туулсүрэн
10	Мөст сумын сургууль	Захирал	Л.Тогтохбаяр
11	Мөст сумын цэцэрлэг	Эрхлэгч	Т.Оюунцэцэг